



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 7 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

### Гүйцэтгэх захирал, газрын захирлуудын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18 дахь хэсэг, 83 дугаар зүйлийн 83.15 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.5.1 дахь заалт, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1 дэх заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд нээлттэй сонгон шалгаруулалт зарласугай.
2. Гүйцэтгэх захиралтай байгуулсан "Хөлсөөр ажиллах гэрээ"-г сонгон шалгаруулалт дуусах хүртэл хугацаанд сунгасугай.
3. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Газрын захирлуудын нээлттэй сонгон шалгаруулалтыг Гүйцэтгэх захирлыг томилсны дараа зохион байгуулахыг Нэр дэвшүүлэх хороо (Н.Отгончимэг)-нд даалгасугай.
4. Нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг Нэгдүгээр хавсралт, нэр дэвшигчийн үнэлгээний хуудсыг Хоёрдугаар хавсралт, сонгон шалгаруулалтын төлөвлөгөөг Гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
5. Батлагдсан төлөвлөгөөний дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллахыг Нэр дэвшүүлэх хороо (Н.Отгончимэг)-нд үүрэг болгосугай.
6. Сонгон шалгаруулалтын зарыг компанийн албан ёсны цахим хуудас, өдөр тутмын сонин хэвлэл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим хуудас, Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн дотор нийтлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Тэмүүжин)-д даалгасугай.
7. Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан Хөлсөөр ажиллах гэрээний 2023 оны биелэлтийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөрт багтаан Нэр дэвшүүлэх хороонд ирүүлэхийг Гүйцэтгэх захирал (Х.Алтай)-д даалгасугай.
8. Гүйцэтгэх захирлын 2023 оны гэрээний биелэлтийг дүгнэж 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс өмнө Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахыг Нэр дэвшүүлэх хороо (Н.Отгончимэг)-нд даалгасугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1523010126



## “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дахь хэсэг, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.28, 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг үндэслэн Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

**Гүйцэтгэх захирлын албан тушаалд нэр дэвшигчид тавигдах шаардлага, шалгуур:**

### Боловсрол

- Санхүү, эдийн засаг, хууль, эрх зүйн дээд боловсролтой;
- Англи хэлний ахисан төвшний мэдлэгтэй.

### Ур чадвар

- Асуудлыг шийдвэрлэх болон дүн шинжилгээ хийх, бодлого төлөвлөх боловсруулах;
- Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг оновчтой, шуурхай удирдан зохион байгуулах;
- Мэргэжлийн өндөр чадвартай

### Туршлага

- Санхүүгийн салбарт удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай байх;
- Компанийн үйл ажиллагааны менежментийг хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах, төр, бизнесийн салбарын уялдааг ханган ажиллах мэдлэг туршлагатай байх;
- Санхүүгийн зах зээлийн томоохон төсөл, хөтөлбөр дээр ажиллаж байсан туршлагатай.

*Жич: Биржийн бодлого, үйл ажиллагааны талаар мэдлэг, туршлагатай, мөн төрийн байгууллагатай харилцан уялдаа холбоотой ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.*

### Бусад шаардлага

- Монгол Улсын иргэн байх;
- Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх;
- Шүүхийн шийдвэрээр эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх;
- Компанитай бизнесийн аливаа холбоогүй (Үнэт цаасны компани, Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд болон бусад өрсөлдөгч байгууллагад удирдах албан тушаалд сүүлийн 3 жил ажиллаагүй байх);
- Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;



- Санхүү, Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэггүй байх;
- Уул уурхайн компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний холбогдох этгээдтэй холбоо хамааралгүй байх;
- Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;
- Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх;
- Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд нь дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон бол энэ нь нэр дэвшигчээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй болох нь нотлогдсон байх;
- Зөрчлийн улмаас санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;
- Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ зөрчлийн шийтгэл хүлээсэн бол үүнээс хойш нэг жил өнгөрсөн байх;
- Өөрөө эсхүл хамаарал бүхий этгээд нь сүүлийн 2 жил өрсөлдөгч компани болон үнэт цаасны компанид ажил, албан тушаал эрхлээгүй байх; /Компани нь Компанийн нэгдэлд хамаарагдаж байгаа бол нэгдлийн бусад хуулийн этгээдэд мөн адил хамаарна/

*Жич: Компанийн засаглалын сургалтад хамрагдсан талаарх гэрчилгээ, Үнэт цаасны зах зээлд ажиллах эрхтэй бол давуу тал болно.*

#### **Бүрдүүлэх материал:**

1. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт;
2. Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа;
3. Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт;
4. Нэр дэвшигчийн дэлгэрэнгүй анкет (Төрийн албан хаагчийн анкет);
5. Анх удирдах албан тушаалд ажиллаж эхэлснээс хойших нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа;
6. Боловсролын дипломын лавлагаа, үнэмлэх, сургалт семинарт хамрагдсан гэрчилгээ сертификатын нотариатаар баталгаажуулсан хуулбар;
7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт;
8. Иргэний үнэмлэхийн лавлагаа;
9. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн үнэт цаас эзэмшлийн тодорхойлолт;
10. Санхүүгийн зохицуулах хорооны тохиромжтой этгээдээр тодорхойлсон тодорхойлолт;
11. Нэр дэвшигчийн баталгаа; *(энэхүү зард хавсаргасан загварын дагуу бөглөж ирүүлнэ үү)*
12. Нэр дэвшигчийн мэдэгдэл; *(энэхүү зард хавсаргасан загварын дагуу бөглөж ирүүлнэ үү)*
13. Бусад шаардлагыг хангасан талаарх нотлох баримт.

#### **Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хугацаа, газар:**

Сонгон шалгаруулалтад орох иргэний материалыг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 17:30 цаг хүртэл Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-

р хороо, Д.Сүхбаатарын талбай-3 "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн байранд /Дотоод аудитор О.Ангирмаа, утас: 89054945/ хүлээн авна.

**Анхаарах зүйлс:**

1. Материалыг нэг дугтуйнд хийн битүүмжилсэн байх ба дугтуйны гадна талд сонгон шалгаруулалтад оролцогч иргэний овог, нэр, оршин суух хаяг, холбоо барих утасны дугаарыг тус тус гаргацтай бичнэ.
2. Дугтуйн дотор сонгон шалгаруулалтын баримт бичгийн жагсаалт, мөн гадна талд нь нийт хуудасны тоог бичиж гарын үсгээ зурсан байна. *(хэрэв бичээгүй тохиолдолд энэ асуудлаар гомдол гаргах эрхгүй болохыг анхаарна уу)*
3. Материалыг сонгон шалгаруулалтын дараа буцаан олгохгүй болно.
4. Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахаас татгалзана.
5. Материалын бүрдэл дутуу тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.
6. Хүчин төгөлдөр бус баримт бичиг ирүүлсэн тохиолдолд баримт бичгийн бүрдэл дутуу гэж үзнэ.
6. Сонгон шалгаруулалтын шаардлага хангасан иргэнтэй Нэр дэвшүүлэх хорооноос холбоо барина.
8. Нэмэлт мэдээллийг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 8681-1212 дугаарын утаснаас авна уу.

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК



Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2023 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн  
... дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралт

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН АЛБАН ТУШААЛД НЭР ДЭВШИГЧИЙН  
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Нэр дэвшигч ...../овог, нэр/

**1. Ирүүлбэл зохих баримт материал**

№	Ирүүлбэл зохих баримт бичиг	Ирүүлсэн эсэх	Хүчин төгөлдөр эсэх	Тайлбар
1	Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт			
2	Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа			
3	Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт;			
4	Нэр дэвшигчийн дэлгэрэнгүй анкет			
5	Анх удирдах албан тушаалд ажиллаж эхэлснээс хойших нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа;			
6	Боловсролын диплом, үнэмлэх, сургалт семинарт хамрагдсан гэрчилгээ сертификатын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;			
7	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт			
8	Иргэний үнэмлэхийн лавлагаа			
9	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн үнэт цаас эзэмшлийн тодорхойлолт;			
10	Санхүүгийн зохицуулах хорооны тохиромжтой этгээдээр тодорхойлсон тодорхойлолт;			
12	Нэр дэвшигчийн баталгаа (энэхүү зард хавсаргасан загварын дагуу бөглөж ирүүлнэ үү)			
13	Нэр дэвшигчийн мэдэгдэл (энэхүү зард хавсаргасан загварын дагуу бөглөж ирүүлнэ үү)			
14	Бусад шаардлагыг хангасан талаар нотлох баримт.			

## 2. Шаардлага хангаж байгаа эсэх талаарх үнэлгээ

№	Тавигдах шаардлага	Нотлох баримт	Нотлох баримт хүчин төгөлдөр эсэх	Шаардлага хангаж байгаа эсэх
1	Санхүү, эдийн засаг, хууль, эрх зүйн дээд боловсролтой;	Дипломны хуулбар эсхүл Дээд боловсролын сургалтын байгууллагын дипломын тодорхойлолт,		
2	Санхүүийн салбарт удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай байх	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа		
3	Монгол Улсын иргэн байх	Иргэний үнэмлэхний лавлагаа		
5	Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх	Иргэний үнэмлэхний лавлагаа		
6	Шүүхийн шийдвэрээр эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх;	Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт		
7	Компанитай бизнесийн аливаа холбоогүй (Үнэт цаасны компани, Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд болон бусад өрсөлдөгч байгууллагад удирдах албан тушаалд сүүлийн 3 жил ажиллаагүй байх);	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт		
8	Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;	Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт		
9	Санхүү, Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компанийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэггүй байх;	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжын төвийн тодорхойлолт Нэр дэвшигчийн мэдэгдэл баталгаа		
10	Уул уурхайн компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний холбогдох этгээдтэй холбоо хамааралгүй байх;	Нэр дэвшигчийн мэдэгдэл, баталгаа		
11	Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;	Нэр дэвшигчийн баталгаа		
12	Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан тохиромжтой этгээдтийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх	Нэр дэвшигчийн баталгаа		



13	Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй болох нь нотлогдсон байх;	Нэр дэвшигчийн баталгаа		
14	Зөрчлийн улмаас санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;	Нэр дэвшигчийн баталгаа		
15	Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ зөрчлийн шийтгэл хүлээсэн бол үүнээс хойш нэг жил өнгөрсөн байх;	Нэр дэвшигчийн баталгаа		
16	Өөрөө эсхүл хамаарал бүхий этгээд нь сүүлийн 2 жил өрсөлдөгч компани болон үнэт цаасны компанид ажил, албан тушаал эрхлээгүй байх; /Компани нь Компанийн нэгдэлд хамаарагдаж байгаа бол нэгдлийн бусад хуулийн этгээдэд мөн адил хамаарна/	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа		

Нэр дэвшигч шаардлага хангаж байгаа эсэх: Тийм/үгүй

Нэр дэвшигч шаардлага хангаагүй талаарх үндэслэл:

1. Баримт бичгийн бүрдүүлбэр дутуу
2. Хүчин төгөлдөр бус баримт бичиг ирүүлсэн
3. Худал мэдээлэл ирүүлсэн нь нотлогдсон

**Тайлбар:** /энэ хэсэгт нэр дэвшигч шаардлага хангаагүй талаар дээр дурдсан дээр нэмж тайлбар гаргаж нотлох баримтыг дурдах эсхүл дээр дурдсанаас өөр үндэслэл байгаа бол бичнэ/

.....  
 .....  
 .....

Үнэлгээ хийсэн:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны Дарга/гишүүн  
 ...../Овог, нэр/...../Гарын үсэг/

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2023 оны 12 дугаар сарын 07-ны  
өдрийн ... дугаар тогтоолын  
Гуравдугаар хавсралт

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ГАЗРЫН  
ЗАХИРЛУУДЫГ НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

<b>Нээлттэй сонгон шалгаруулалтын үе шат</b>		
<b>1</b>	Нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлах	<b>2023.12.08</b>
<b>2</b>	Материал хүлээн авах сүүлийн хугацаа	<b>2023.12.21</b>
<b>3</b>	Нэр дэвшүүлэх хороо ирүүлсэн материалын хүрээнд үнэлгээ хийж дүгнэлт гаргах	<b>2023.12.22</b>
<b>4</b>	Авлигатай тэмцэх газар руу нэр дэвшигчдийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулахаар хүсэлт хүргүүлэх	<b>2023.12.22</b>
<b>5</b>	Нэр дэвшигчдийг ТУЗ-ийн хурлаар танилцуулж, ярилцлага хийж, санал хурааж, томилох	<b>2024.01.11</b>

---o0o---